

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан

Агуулга

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал .....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	13
1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	19

## Аудитын гэрчилгээ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА Л.НОМИН  
ТАНАА

2020.02.24 № 06/551  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### **Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга Л.Номин Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт, биет бус хөрөнгийн бүртгэл, тайлагнал, батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 05-наас 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Л.Мөнхцацрал хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах бодлого, зохицуулалтаар хангахад оршино.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг актуар тооцоололд үндэслэн боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих;

- Эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг хянах, үнэлэлт, дүгнэлт өгөх;

- Эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;

- Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад орох тусламж, үйлчилгээний жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах;

- Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаар, энэ хуулийн 11.2-т заасан даатгуулагчийн төлөх төлбөрийн хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тухай бүр тогтоох;

- Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох;

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан чиг үүрэг.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ны Acolous программ хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтыг үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын мөнгөн гүйлгээний тайлангийн нийт мөнгөн орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 210,928.2 мянган төгрөгөөс тооцон 4,218.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,266.3 мянган төгрөгөөр тогтоосон нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс тооцсонтой холбоотой юм.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,298.4 мянган төгрөгөөр буюу 33.1 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,010.6	0	(2,010.6)
Авлага	900.3	0	(900.3)
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	2,172.7	2,511.9	339.3
Үндсэн хөрөнгө	4,872.4	10,313.4	5,570.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>9,955.9</b>	<b>13,254.3</b>	<b>3,298.4</b>
Өр төлбөр	854.3	0	(854.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,101.6	13,254.3	4,152.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>9,955.9</b>	<b>13,254.3</b>	<b>3,298.4</b>

Тайлант онд 900.3 мянган төгрөгийн авлага, 854.3 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 339.3 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын 1,799.5 мянган төгрөг, бичиг хэргийн материалын 476.3 мянган төгрөг, шатахууны талоны 200.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь эд хогшил, урсгал засварын зардлын төсвөөс 8,135.2 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж, 679.8 мянган төгрөгийн



тавилга хэрэгсэл, мэдээлэл технологийн зардлын төсвөөс 847.0 мянган төгрөгийг програм хангамж тус тус бэлтгэснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13,254.3 мянган төгрөг болж, тайлант оны үр дүн 4,152.7 мянган төгрөгөөр өссөн байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан Эрүүл мэндийн даатгалын сангаас 313,317.1 мянган төгрөгийн төсвийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлыг 313,317.1 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 234,395.3 мянган төгрөг зарцуулж, 78,921.3 мянган төгрөгөөр төсвийг хэмнэсэн байна.

Тайлант онд төсвийн ангилал, бүлгээр хэтэрсэн зардалгүй, төсвийн хэмнэлтэд орон тоо дутуу ажилласнаас үүдэж цалин хөлс ба нэмэгдэл урамшил 76,059.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 4,859.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилт батлагдаагүй боловч Сангийн сайдын 2014 оны Эдийн засгийн ангилал батлах тухай 55 дугаар тушаалд “2106 Эд хогшил, урсгал засварын зардалд байгууллага эд хогшил худалдан авах болон үндсэн хөрөнгөд урсгал засвар, үйлчилгээ хийлгэхтэй холбоотой зардлуудыг тус бүлэгт бүртгэнэ”, “2108 Мэдээлэл, технологийн үйлчилгээний зардалд байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажиллагсдын ашиглах хэрэглээний програмууд, лицензийн төлбөр, тэдгээрийн засвар үйлчилгээг гуравдагч этгээдээс худалдан авахтай холбоотойгоор гарах зардлыг бүртгэнэ” гэж тус тус заасны дагуу 9,622.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 4,156.7 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснийг 4,156.7 мянган төгрөгийн 4 алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж, нэг зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба нь 2019 онд шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх, олон нийт хяналт тавих тогтолцоог бүрдүүлж ажиллаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна: 3.2.1.улс, орон нутгийн төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэж заасанд нийцэхгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар гүйцээж шалгаагүй горим сорил болон анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба нь 2018 онд шинээр үүсгэн байгуулагдсан бөгөөд 2019 онд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллагаагүй байна. Аудитаар зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгч ажиллалаа.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,832.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 12,950.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 18,604.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгснийг, завсрын аудитаар хянахад хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулаагүй 4,156.7 мянган төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 6,266.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Зохицуулалтын зөвшөөрөлгүйгээр эдийн засгийн ангилал зөрчиж 1,180.0 мянган төгрөгийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасанд нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Төсөв хэтрэх, төсвийн зарчим хэрэгжихгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2014 оны “Эдийн засгийн ангилал батлах тухай” 55 дугаар тушаал, Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай 7 дугаар тушаалд нийцүүлж батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар илэрсэн асуудлыг бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

#### 3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт: Анхан шатны баримт бүрдэл дутуу 897.4 мянган төгрөгийн зардлын гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасанд нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл: Үргүй зардал гарах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчигдөх

3.2.3. Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримт, бүрдэлгүй ажил гүйлгээг санхүүгийн тайланд бүртгэхгүй байх

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар илэрсэн асуудлыг бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

### **3.3 Дотоод хяналттай холбоотой асуудал**

3.3.1. Илрүүлэлт: Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14.9.1-г хэрэгжүүлэх үүднээс ЭМДҮЗ-ийн Ажлын албанд дотоод аудитораар 2 ажилтан томилогдсон боловч даатгалын сангийн төсөв, санхүүд хяналт тавьж ажиллаагүй нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.1-т “эрүүл мэндийн даатгалын сангийн болон эрүүл мэндийн даатгалын байгууллагын ... батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг батлах, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэж заасанд нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл: Сангийн санхүүгийн үйл ажиллагаа эрсдэлийн удирдлагаар хангагдахгүй байх, алдаа зөрчил үүсэх

3.3.3. Өгсөн зөвлөмж: “Эрүүл мэндийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах” чиг үүргийг хангаж ажиллах

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар илэрсэн асуудлыг бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

### **3.4 Бараа материалын данстай холбоотой асуудал**

3.4.1. Бараа материалын тайланд нийт 2,079.3 мянган төгрөгийн аж ахуйн материалыг багц дүнгээр орлогод авч, зарцуулсан /бараа материалыг нэр төрөл тус бүрээр бүртгээгүй/ нь Сангийн сайдын 2006 оны 388-Төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар-ын 4.16-д “Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө” гэж заасанд нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл: Бараа материал үргүй зарцуулагдах

3.4.3. Өгсөн зөвлөмж: Бараа материалыг нэр төрөл тус бүрээр ангилж бүртгэх, жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлах

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар илэрсэн асуудлыг бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

**1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,083,521.9	2,511,950.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,010,565.9	00.0
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,010,565.9	00.0
3121	Төгрөг	2,010,565.9	00.0
31211	Төрийн сангийн харилцах	2,010,565.9	00.0
33	АВЛАГА	900,252.0	00.0
335	Бусад авлага	900,252.0	00.0
3351	Байгууллагаас авах авлага	900,252.0	00.0
35	БАРАА МАТЕРИАЛ	2,172,704.0	2,511,950.0
354	Хангамжийн материал	2,172,704.0	2,511,950.0
35410	Бичиг хэргийн материал	196,422.0	471,668.0
35420	Аж ахуйн материал	515,996.0	40,796.0
35440	Түлш, шатах тослох материал	165,000.0	200,000.0
35470	Бусад хангамжийн материал	1,295,286.0	1,799,486.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,872,387.3	10,742,352.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,872,387.3	10,742,352.6
392	Биет хөрөнгө	4,872,387.3	10,313,352.6
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,355,714.0	13,490,914.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-483,326.7	-3,834,701.4
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	00.0	679,800.0
39208	Хуримтлагдсан элэгдэл		
393	Биет бус хөрөнгө	00.0	429,000.0
39301	Програм хангамж	00.0	847,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.0	-418,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,955,909.2	13,254,302.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	854,321.0	00.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	854,321.0	00.0
413	Өглөг	854,321.0	00.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	854,321.0	00.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,101,588.2	13,254,302.6
51	Засгийн газрын хувь оролцоо	9,101,588.2	13,254,302.6
512	Хуримтлагдсан үр дүн	9,101,588.2	13,254,302.6
51210	Өмнөх үеийн үр дүн	9,101,588.2	9,101,588.2
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	4,152,714.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,955,909.2	13,254,302.6

## 1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	147,428,800.0	313,317,100.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	147,428,800.0	313,317,100.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	147,428,800.0	313,317,100.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	147,428,800.0	313,317,100.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	138,327,211.8	309,164,385.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,327,211.8	309,164,385.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	137,745,011.8	221,899,515.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	108,394,026.2	164,274,665.6
210102	Нэмэгдэл	12,914,451.0	138,277,820.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,643,242.0	4,912,702.9
210104	Урамшуулал	91,836,333.2	21,084,142.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,680,577.0	25,176,296.7
210201	Тэтгэврийн даатгал	7,359,477.0	17,563,287.7
210202	Тэтгэмжийн даатгал	1,084,700.0	1,963,749.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	795,300.0	1,605,443.0
210204	Ажилгүйдлийн даатгал	271,600.0	358,083.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,169,500.0	3,685,734.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,086,082.0	7,442,205.0
210401	Бичиг хэрэг	1,860,994.0	2,904,554.0
210402	Тээвэр, шатахуун	2,335,000.0	2,465,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,890,088.0	2,072,651.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	534,997.0
210601	Багаж, техник хэрэгсэл	-	534,997.0
2107	Томилолт, зочны зардал	3,324,000.0	8,529,440.0
210702	Дотоод албан томилолт	3,324,000.0	8,529,440.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,140,000.0	2,746,200.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,140,000.0	838,300.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,907,900.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,120,326.7	13,195,710.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,637,000.0	9,403,676.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	483,326.7	3,792,034.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	582,200.0	87,264,870.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	582,200.0	2,500,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	2,500,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	582,200.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,832,485.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,832,485.9
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	80,932,384.7
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	80,932,384.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9,101,588.2	4,152,714.4
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,101,588.2	4,152,714.4

### 1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>147,428,800.0</u>	<u>313,317,100.0</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	147,428,800.0	313,317,100.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	147,428,800.0	313,317,100.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	147,428,800.0	313,317,100.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>140,062,520.2</u>	<u>305,665,665.9</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	140,062,520.2	305,665,665.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	139,480,320.2	220,222,715.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	107,121,634.2	164,228,734.6
210102	Нэмэгдэл	12,914,451.0	138,231,889.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,643,242.0	4,912,702.9
210104	Урамшуулал	90,563,941.2	21,084,142.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,998,900.0	25,176,296.7
210201	Тэтгэврийн даатгал	8,677,800.0	17,563,287.7
210202	Тэтгэмжийн даатгал	1,084,700.0	1,963,749.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	795,300.0	1,605,443.0
210204	Ажилгүйдлийн даатгал	271,600.0	358,083.0
210205	Эрүүл мэндийн даатгал	2,169,500.0	3,685,734.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,294,589.0	7,196,451.0
210401	Бичиг хэрэг	2,034,600.0	2,607,100.0
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.0	2,500,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,759,989.0	2,089,351.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	135,997.0	684,997.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	135,997.0	684,997.0
2107	Томилолт, зочны зардал	3,324,000.0	8,529,440.0
210702	Дотоод албан томилолт	3,324,000.0	8,529,440.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,140,000.0	5,003,120.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,140,000.0	2,079,800.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,563,320.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	360,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,465,200.0	9,403,676.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,465,200.0	9,403,676.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	582,200.0	85,442,950.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	582,200.0	2,500,000.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	2,500,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	582,200.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,010,565.9
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,010,565.9

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	80,932,384.7
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	80,932,384.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>7,366,279.9</u>	<u>7,651,434.2</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,355,714.0	9,662,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,355,714.0	9,662,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	5,355,714.0	9,662,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,355,714.0	9,662,000.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,355,714.0)</u>	<u>(9,662,000.0)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,010,565.9	(2,010,565.9)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,010,565.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,010,565.9	-



#### 1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	9,101,588.2	-	9,101,588.2
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	9,101,588.2	-	9,101,588.2
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	9,101,588.2	-	9,101,588.2
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	4,152,714.4	-	4,152,714.4
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	13,254,302.6	-	13,254,302.6

### 1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,010,565.9	(2,010,565.9)	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	313,317,100.0	234,395,281.1	78,921,818.9	75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	313,317,100.0	234,395,281.1	78,921,818.9	75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	310,817,100.0	229,884,715.3	80,932,384.7	74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,288,500.0	164,228,734.6	76,059,765.5	68
210102	Нэмэгдэл	190,092,700.0	138,231,889.7	51,860,810.3	73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,240,000.0	4,912,702.9	4,327,297.2	53
210104	Урамшуулал	40,955,800.0	21,084,142.0	19,871,658.0	51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,036,100.0	25,176,296.7	4,859,803.3	84
210201	Тэтгэврийн даатгал	20,424,500.0	17,563,287.7	2,861,212.3	86
210202	Тэтгэмжийн даатгал	2,402,900.0	1,963,749.0	439,151.0	82
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,922,300.0	1,605,443.0	316,857.0	84
210204	Ажилгүйдлийн даатгал	480,600.0	358,083.0	122,517.0	75
210205	Эрүүл мэндийн даатгал	4,805,800.0	3,685,734.0	1,120,066.0	77
2104	Хангамж, бараа материалын зардал	7,202,200.0	7,196,451.0	5,749.0	100
210401	Бичиг хэрэг	2,607,100.0	2,607,100.0	-	100
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.0	2,500,000.0	-	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,095,100.0	2,089,351.0	5,749.0	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,500,000.0	9,499,997.0	3.0	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,500,000.0	9,499,997.0	3.0	100
2107	Томилолт, зочны зардал	8,534,400.0	8,529,440.0	4,960.0	100
210702	Дотоод албан томилолт	8,534,400.0	8,529,440.0	4,960.0	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,850,900.0	5,850,120.0	780.0	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,080,000.0	2,079,800.0	200.0	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,410,900.0	3,410,320.0	580.0	100
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	360,000.0	360,000.0	-	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,405,000.0	9,403,676.0	1,324.0	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,405,000.0	9,403,676.0	1,324.0	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500,000.0	4,510,565.9	(2,010,565.9)	180
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.0	2,500,000.0	-	100
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,500,000.0	2,500,000.0	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	313,317,100.0	232,384,715.3	80,932,384.7	74
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих			-	

1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	313,317,100.0	232,384,715.3	80,932,384.7	74
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	313,317,100.0	232,384,715.3	80,932,384.7	74
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,010,565.9	(2,010,565.9)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	21	16	5	76
620001	Удирдах ажилтан	3	3	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	18	13	5	72
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21	16	5	76
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	18	16	2	89
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	-	3	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2019			САГ-2020/234/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажлын албанд дотоод аудиторoor 2 ажилтан томилогдсон боловч даатгалын сангийн төсөв, санхүүд хяналт тавьж, эрсдэлийн удирдлагаар хангаж ажиллаагүй байна.		Зөвлөмж өгөх	Ажлын албаны дарга, Нягтлан бодогч	Л.Номин, Д.Сувдаа
2	Бараа материалын тайланд нийт 2,079.3 мянган төгрөгийн аж ахуйн материалыг багц дүнгээр орлогод авч, зарцуулсан	2,079.3	Зөвлөмж өгөх	Ажлын албаны дарга, Нягтлан бодогч	Л.Номин, Д.Сувдаа
3	Анхан шатны баримт бүрдэл дутуу 897.4 мянган төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч зардалд бүртгэсэн	897.4	Зөвлөмж өгөх	Ажлын албаны дарга, Нягтлан бодогч	Л.Номин, Д.Сувдаа
4	Эдийн засгийн ангилал зөрчиж 1,180.0 мянган төгрөгийн зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан	1,180.0	Зөвлөмж өгөх	Ажлын албаны дарга, Нягтлан бодогч	Л.Номин, Д.Сувдаа
5	Тайлант онд шилэн данс хөтөлж, мэдээлэл байршуулаагүй байна.		Албан шаардлага	Ажлын албаны дарга, Нягтлан бодогч	Л.Номин, Д.Сувдаа



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 03

№ 01/66

Улаанбаатар хот

САГ-2020/234/СТА-ТШЗ

Зөрчлийг арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасан цаглабарт хугацаанд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба нь 2019 онд шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх, олон нийт хяналт тавих тогтолцоог бүрдүүлж ажиллаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна: 3.2.1.улс, орон нутгийн төсөв болон Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 12-т заасан “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албаны дарга П.Номин, нягтлан бодогч Д.Сувдаа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

өгсөн:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Л.МӨНХЦАЦРАЛ

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН  
АЛБАНЫ ДАРГА

Л.НОМИН

НЯГТЛАН БОДОГЧ

Д.СУВДАА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчлil гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халгах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig\_Kherig\Alban Shaardlaga\2020\03035AG12.Docx

001080221



## ТЭМДЭГЛЭЛ

A series of 25 horizontal dotted lines for writing.

